



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН ЗДТГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2022/78/НА-СА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2022 он



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.ДЭЛГЭРЖАРГАЛ ТАНАА

2022.02.14 № 70
танай _____ -ны № _____ -т



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/



009020037

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	181,064,761.50	117,722,534.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	499,141,616.84	504,687,165.52
	Нийт хөрөнгийн дүн	<u>680,206,378.34</u>	<u>622,409,699.52</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	872,324.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	680,206,378.34	621,537,375.52
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>680,206,378.34</u>	<u>622,409,699.52</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	584,313,152.20	570,737,072.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	565,428,385.32	617,447,794.82
	Үйл ажиллагааны үр дүн	<u>18,884,766.88</u>	<u>(46,710,722.82)</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(75,803,377.24)	(11,958,280.00)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>(56,918,610.36)</u>	<u>(58,669,002.82)</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	736,395,788.70	680,206,378.34
	Тайлант оны үр дүн	(56,918,610.36)	(58,669,002.82)
	Эцсийн үлдэгдэл	<u>680,206,378.34</u>	<u>621,537,375.52</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	593,798,728.00	592,528,978.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	490,321,928.00	580,784,388.00
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>103,476,800.00</u>	<u>11,744,590.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(23,476,800.00)</u>	<u>(7,439,900.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	<u>80,000,000.00</u>	<u>4,304,690.00</u>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<u>504,184,700.00</u>	<u>486,890,944.67</u>
	Урсгал зардал	<u>504,184,700.00</u>	<u>486,890,944.67</u>
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	<u>467,251,900.00</u>	<u>486,890,944.67</u>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	452,691,900.00	475,953,340.67
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14,560,000.00	10,937,604.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ЗДТГ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үндсэн үүрэг бүхий байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Орхон сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 24,380.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 1 залруулга, 2 төлбөрийн акт тогтоов.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтын 16,408.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 6.4.8-д заасан өр авлага үүсгэсэн 5,837.3 мянган төгрөгийн 7 шийдвэр, нийт 22,246.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулга хийлгэсэн болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар Засаг даргын орлогч Б.Түмэнцогт, ЗДТГ-ын дарга С.Дэлгэржаргал нарт хууль, журамд заасан урамшууллыг илүү тооцож 1,754.2 мянга, сахилгын шийтгэлтэй байсан О.Дамдинсүрэн, Н.Цэдэн-Иш нарт үр дүнгийн урамшуулал тооцож 380.6 мянга, нийт 2,134.8 мянган төгрөг олгосон зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагдсан	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	24,380.8	1	22,246.0	2	2,134.8				
	НИЙТ	3	24,380.8	1	22,246.0	2	2,134.8				